



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/561

Улаанбаатар хот

Эмийн жор цахимаар бичих, олгох түр
заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль"-ийн 29 дүгээр зүйлийн 29.4.3 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад тус тус үндэслэн ТУШААХ нь:


1."Эмийн жорын маягт, жор бичилт" MNS 5376:2016 6.1-д зааснаар эмийн жорын хяналтыг сайжруулах, жор бичилтийг бүртгэх, жорын дагуу эм худалдан авах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор "Эмийн жор цахимаар бичих, олгох түр заавар"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Эмийн жор цахимаар бичих, олгох үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Стратеги төлөвлөлтийн газрын дарга (П.Оюунцэцэг), хэрэгжилтийг ханган ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/495 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141242363

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
16 дугаар сарын 10-ны өдрийн
1521 дугаар тушаалын хавсралт

ЭМИЙН ЖОР ЦАХИМААР БИЧИХ, ОЛГОХ ТҮР ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү зааврыг Эрүүл мэндийн тухай хуулийн 15-р зүйлийн 15.1-д заасан эрүүл мэндийн байгууллага болон эмийн сан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2, 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, 10.5, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4 дэх хэсэгт тус тус үндэслэн эмийн жорыг цахимаар бичиж, олгоход мөрдөнө.

1.2 "Эмийн жорын маягт, жор бичилт" MNS 5376:2016 стандартын 4.1-т заалтад заасан эмийн жорыг цахимаар бичиж эмийн санд дамжуулж буй хэлбэр нь "цахим жор" байна.

1.3 Үндэсний дата төв дээр байрлах цахим системд цахим жорыг бүртгэх, хянах, хамгаалах, хадгалах, ашиглах, баяжуулах зориулалт бүхий "эмийн цахим жорын систем" байна.

1.4 Эмийн цахим жор бүрд цахим жорын системээс олгогдох давтагдахгүй "хяналтын дугаар" бүхий кодыг олгоно.

1.5 Эмч өөрийн регистрийн дугаараар эмийн "цахим жорын системд нэвтрэх эрх"-тэй байна.

1.6 Эмчид цахим жорын системд нэвтрэх эрх олгох эрх бүхий албан хаагч нь "админ" байна.

Хоёр. Цахимаар жор бичих

2.1 Эмч цахим жор бичихэд "Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016 стандарт болон энэхүү зааврыг баримтална.

2.2 Эмч үйлчлүүлэгчийн мэдээллийг бүрэн авч, нягталсны үндсэн дээр эмийн цахим жорыг бичнэ.

2.3 Эмийн дан болон нийлмэл найрлагаас үл хамааран олон улсын нэршлээс сонгож, эмийн цахим жорыг бичнэ.

2.4 Эмч үйлчлүүлэгчид цахим жорд бичсэн эмийн тун хэмжээ, хэрэглэх арга, эмчилгээний үргэлжлэх хугацаа, илэрч болзошгүй гаж нөлөөний талаар заавал тайлбарласан байна.

2.5 Эмч цахим жорыг алдаатай бичсэнээс иргэн эмийг худалдан аваагүй тохиолдолд тус жорыг бичсэн эмч өөрийн эрхээр жорыг засварлах буюу цуцлах эрхтэй байна.

2.6 Цахим жорын хяналтын дугаар цахим системд үүсэх ба тус дугаарыг үйлчлүүлэгчид бичиж өгнө.

2.7 Эмч үйлчлүүлэгчийн биеийн байдал, нөхцөл байдлыг үнэлсний үндсэн дээр цахим жорыг 3 сар хүртэлх хугацаагаар бичиж болно.

2.8 Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн жор бичих

2.8.1 Эмч үйлчлүүлэгчид хөнгөлөлттэй эмийн цахим жор бичихдээ үйлчлүүлэгчийг регистрийн дугаараар нь бүртгэх ба үзлэгийн тэмдэглэлийг цахимд бичиж оруулан, оношийг олон улсын өвчний ангиллын дагуу кодолж, эмчилгээний үргэлжлэх хугацааг сонгон цахим жорын системээс олон улсын ерөнхий нэршлээр эмийн нэр, тун хэмжээг сонгож, олгох тоо ширхгийг бичнэ.

2.8.2 0-16 насны хүүхдэд эмийн цахим жор бичихдээ асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хурууны хээгээр баталгаажуулна.

2.8.3 Хурууны хээ нь танигдахгүй үйлчлүүлэгч болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн мэдээллийг цахим жорын систем дэх сангаас иргэний үнэмлэхээр баталгаажуулна.

2.8.4 Эмч цахим жорыг өөрийн болон үйлчлүүлэгчийн хурууны хээгээр баталгаажуулна.

2.9 Энгийн эмийн жор бичих

2.9.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмээс бусад жороор олгох эмийг энгийн болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жороор бичнэ.

2.9.2 Үйлчлүүлэгчийг регистрийн дугаараар бүртгэх ба үзлэгийн тэмдэглэлийг цахимаар бичиж оруулан, эмийн цахим жорын системээс олон улсын нэршлээр эмийн нэр, тун, хэмжээг сонгож, олгох тоо ширхгийг бичнэ.

2.10 Сэтгэцэд нөлөөт эмийн жор бичих

2.10.1 Сэтгэцэд нөлөөт эмийг цахим жороор бичихдээ “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2016 стандартын 5.4, 5.5-д заасан /цахим/ маягтыг ашиглан бичиж, холбогдох хяналт тавих тухайн эрүүл мэндийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр заавал баталгаажуулсан байна.

2.11 Мансууруулах эмийн жор бичих

2.11.1 Мансууруулах эмийг цахим жороор бичихдээ “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2016 стандартын 5.8, 5.9-д заасан /цахим/ маягтыг ашиглан бичиж, холбогдох хяналт тавих тухайн эрүүл мэндийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр заавал баталгаажуулсан байна.

Гурав. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

3.1 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь Эмийн сангийн холбогдох албан тушаалтантай "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, мөрдөн ажиллана.

3.2 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үүрэг

3.2.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэхээр батлагдсан эмийн жагсаалт шинэчлэгдэх бүрд эмийн нэр, үнэ, хөнгөлөлтийн хувь хэмжээг эмийн цахим жорын системд шинэчлэн оруулна.

3.2.2 Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй эм олгох үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7 дахь заалтын дагуу хийнэ.

3.2.3 Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас ирүүлсэн эмийн бүртгэлийн систем буюу лэйсмед мэдээллийн сан, "Эмийн жорын маягт, жор бичилтийн стандарт"-д үндэслэн цахим системийн хөгжүүлэлтийг хийнэ.

3.2.4 ХУР системд байршуулсан иргэний талаар эмзэг мэдээллийг зөвхөн гэрээ бүхий төрийн байгууллага хооронд солилцоно.

3.2.5 Эмийн сангийн болон эрүүл мэндийн байгууллагын цахим программ хөгжүүлэгч байгууллагууд, мэргэжлийн холбоодод холбогдох гарын авлага болон түүнд орсон өөрчлөлтийг тухай бүрд нь хүргүүлнэ.

3.2.6 Эрүүл мэндийн байгууллагатай "Хэрэглэгчийн нууцлал, аюулгүй байдлын гэрээ" байгуулж, мөрдөн ажиллана.

3.2.7 Цахим жорын системийн мэдээллийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт сервисээр дамжуулна.

3.3 Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үүрэг

3.3.1 Эмийн бүртгэлийн систем буюу лэйсмед мэдээллийн санд өөрчлөлт оруулсан бол тухай бүрд нь буюу ажлын 1 өдрийн дотор Эрүүл мэндийн даатгалын газарт мэдээллийг хүргүүлнэ.

3.3.2 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт Эмийн цахим жорын системийн хөгжүүлэлт хийх саналыг хүргүүлнэ.

3.3.3 Цахим жорын системийн мэдээллийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сервисээр дамжуулан авч, дашбоардыг бодит цагийн мэдээллээр гарган ил тод нээлттэй байршуулна.

3.3.4 Зах зээлд тасалдал үүссэн болон тасалдалгүй болсон эмийн талаарх мэдээллийг тухай бүр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.

3.4 Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын үүрэг

3.4.1 Эмийн цахим жорын систем хэрэглэх талаар өөрийн харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

3.4.2. Эмийн цахим жор бичилтийн талаар тогтмол хяналт тавьж ажиллана.

3.5 Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

3.5.1 Эрүүл мэндийн бүх шатны байгууллагын эмч нар эмийн жорыг эмийн цахим жорын системээр бичнэ.

3.5.2 Эрүүл мэндийн байгууллага нь эмийн цахим жор бичихэд шаардагдах техник тоног төхөөрөмж (хурууны хээ уншигч)-өөр бүрэн хангасан байна.

3.5.3 Эрүүл мэндийн байгууллага нь эмчид цахим жорын системд нэвтрэх эрхийг олгох, хаах, сэргээх, шилжүүлэх, цуцлах зэрэг зохицуулалтыг хариуцах админтай байна.

3.5.4 Эрүүл мэндийн байгууллага нь эмч нарт Эмийн цахим жорын системд нэвтрэх эрхээ бусдад дамжуулан ашиглуулахгүй, зүй бусаар ашиглахгүй, хувь хүний нууцыг задруулахгүй байх талаар анхааруулж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллана.

3.6 Эмийн сангийн үүрэг

3.6.1 Эмийн сан эмийн цахим жороор үйлчлэхдээ “Эмийн санд тавих нийтлэг шаардлага” MNS 5260:2015 стандартыг баримтална.

3.6.2 Жор баригч үйлчлүүлэгчийн цахим жорын хяналтын дугаарыг баримтлан эмийг олгоно.

3.6.3 Насанд хүрээгүй хүүхдэд бичсэн жорыг регистрийн дугаар болон цахим жорын хяналтын дугаарыг баримтлан асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгоно.

3.6.4 Үйлчлүүлэгчид эмийг олгохдоо эмийн нэр, тун хэлбэр, тоо хэмжээг эмийн цахим жорын системийн мэдээллийн дагуу сайтар хянаж олгоно.

3.6.5 Цахим жорд эмийн нэр, тун, тоо хэмжээ нь андуурагдсан, эргэлзээтэй байж болзошгүй, болон эмийн үл нийцэл бүхий эм байвал эмийн цахим жор бичсэн эмчээс зайлшгүй тодруулна.

3.6.6 Эмийг олгохдоо эмийн хэрэглэх арга, хадгалах нөхцөл, эмийн зохистой хэрэглээний талаар үйлчлүүлэгчид мэдээлэл өгнө.

3.6.7 Цахим жороор бичигдсэн эмийн аль нэг нь тухайн эмийн санд байхгүй тохиолдолд худалдан авсан эмийг олгож, аваагүй эмийн жор хүчинтэй үлдэх талаар үйлчлүүлэгчид заавал мэдээлэл өгнө.

3.6.8 Эмийн цахим жор нь эмийн олон улсын нэршлээр бичигдэх тул үйлчлүүлэгчид эмийн худалдааны нэршлийн талаар тайлбарлаж, 2 талт дэлгэцийг иргэдэд харагдахуйц байрлуулж, хэд хэдэн худалдааны нэршлийн эмээс сонголт хийх боломжийг олгоно.

3.6.9 Үзлэг хийлгэж цахим жор бичүүлсэн иргэн өөрөө ирээгүй тохиолдолд иргэний үнэмлэхийг үндэслэн эмийг олгож болно.

3.6.10 Жор баригч нь цахим жор дахь иргэний болон эмийн мэдээллийг эргэлзээтэй гэж үзвэл эмчтэй холбогдож, тодруулсны үндсэн дээр эмийг олгохоос татгалзаж болно.

3.7 Программ хөгжүүлэгч байгууллагын үүрэг

3.7.1 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас ирсэн гарын авлагын дагуу системийн хөгжүүлэлтийг хийнэ.

3.7.2 Өөрийн цахим системд бүртгэгдсэн жорын мэдээллийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим жорын системд илгээнэ.

3.7.3 Хамтран ажилладаг Эрүүл мэндийн байгууллага болон эмийн сангийн ажилчдад цахимаар жор бичих, олгох талаар мэдээллээр тогтмол хангана.